



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/186/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn "Ариун төгс оршихуй аудит" ХХК-ийн Ахлах аудитор: Р.Оюунбат Утас: 99023656 Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02.23 № 72

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Чиглэл батлах тухай" 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээгээр 21,460.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Үүнээс байгууллагын менежментийг сайжруулахад 7,511.0 мянган төгрөг, багш ажилчдын урамшуулалд 13,949.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 349,665.2 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 67,877.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандив болон бусад эх үүсвэрээс 67,877.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 9 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 85.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан хүргүүлсэн боловч дээд шатны байгууллагаас дүгнээгүй байна.

0702700359

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	98,618.60	272,434.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	720,856.30	672,255.00
Нийт хөрөнгийн дүн	819,474.90	944,689.00
Нийт өр төлбөрийн дүн	-	690.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	819,474.90	943,998.10
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	819,474.90	944,689.00
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,920,512.30	1,480,348.60
Үйл ажиллагааны зардлын дүн	1,100,252.50	1,355,825.40
Үйл ажиллагааны үр дүн	820,259.80	124,523.20
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	820,259.80	124,523.20
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-784.9	819,474.90
Тайлант оны үр дүн	820,259.80	124,523.20
Эцсийн үлдэгдэл	819,474.90	943,998.10
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,090,348.10	1,424,483.50
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,040,593.70	1,260,324.90
Үйл ажиллагааны ЦМГ	49,754.30	164,158.50
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-37,856.00
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	49,754.30	126,302.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	49,754.30
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,754.30	176,056.90
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,404,823.10
Урсгал зардал	-	1,424,483.50
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,424,483.40
Улсын төсвөөс санхүүжих	-	1,347,659.50
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	73,806.20
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	3,017.70
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	176,056.90



Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 48.2 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан, Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 3.2 сая төгрөгөөр илүү тооцоолсон, ХХОАТ, НДШ-ийн өглөгийг 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлогыг 22.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан, Үр дүнгийн тайланд 19.3 сая төгрөгийн зардлыг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг тус тус зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 11.0 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 11.0 сая төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 2.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 8.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд 0.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд олгосон урамшууллыг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

2. Ажилчдаас 2.2 сая төгрөгийн цалингийн авлага суутгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийцэхгүй, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Суутгаагүй авлагын дүнг суутган авч төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн төсвөөс 8.2 сая төгрөгийг даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх, тайлагнал ба тодруулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг баримтлалгүйгээр нэг хүүхдэд 3475 төгрөгөөр тооцож зарцуулалтыг дутуу хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 24 дүгээр зүйлийн 24.6-т "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", Засгийн газрын 2022 оны 498 дугаар "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолтой тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нормативд зардлыг хэтрүүлэн зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 77 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй 312 хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.-д заасан Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэр гаргуулж шийдвэрлэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Цээл сумын Ерөнхий боловсролын сургууль	5	48.2	-	-	5	48.2	5	48.2	-	-	-	-
Дүн	5	48.2	-	-	5	48.2	5	48.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл


/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цээл сумын Ерөнхий боловсролын сургууль	5	11.0	2	2.8	2	8.2	1	-	-	-
Дүн	5	11.0	2	2.8	2	8.2	1	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн							-	



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-